


# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

[www.1212.mn](http://www.1212.mn)

Статистик мэдээллийн  
нэгдсэн сан



[www.nso.mn](http://www.nso.mn)

Та статистик мэдээллийг байнга  
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**  
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail  
хаягаа бүртгүүлснээр  
статистикийн мэдээллийг  
цаг алдалгүй тогтмол авч  
байх болно.


**SOCIAL NETWORK**



[www.facebook.com/  
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/  
statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет  
ашиглан статистик мэдээлэл  
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл  
бүтээгдэхүүнийг унших  
**Монстат** аппликейшн



Утсаар:



Лавлах утас

**1900-1212**



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**3 сар  
2017**

Улаанбаатар хот

---

---

## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл .....	3
Товч танилцуулга .....	4
Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм .....	27
Үндсэн үзүүлэлтүүд .....	30
I. Хүн ам.....	31
II. Хөдөлмөр.....	34
IV. Нийгмийн даатгал, халамж.....	41
V. Эрүүл мэнд .....	43
VI. Байгаль орчин .....	50
VII. Гэмт хэрэг.....	57
VIII. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл .....	61
IX. Улсын нэгдсэн төсөв .....	68
X. Гадаад худалдаа .....	74
XI. Үнэ .....	87
XII. Бизнес регистрийн сан .....	109
XIII. Хөдөө аж ахуй .....	114
XIV. Аж үйлдвэр .....	118
XV. Их барилга .....	127
XVI. Тээвэр, холбоо .....	130
XVII. Аялал жуулчлал .....	136
Хавсралт .....	140
Аргачлалын тайлбар.....	153

**I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.**

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

**II. Дараах тэмдэглэгээг ашиглав.**

... мэдээлэл байхгүй  
 0.0 маш бага тоо  
 - гүйцэтгэл байхгүй

**III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ**

мянга	=1000
сая	=10 <sup>6</sup>
тэрбум	=10 <sup>9</sup>
их наяд	=10 <sup>12</sup>
мян.	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м2	метр квадрат
дм2	дециметр квадрат
км2	километр квадрат
м3	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(= 10 <sup>9</sup> калори)
с	секунд
мин	минут
мкг/м <sup>3</sup>	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



V. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр excel хэлбэрээр татан авах боломжтой /жич: интернетэд холбогдсон байх ёстой/



VI. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч апп ашиглан тухайн салбарын дэлгэрэнгүй мэдээллийг excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой / жич: интернетэд холбогдсон байх ёстой/

Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

Монгол Улсын нийгэм,  
эдийн засгийн байдал  
(2017 оны эхний улирлын байдлаар)

I. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ




I.1. Хүн ам

Улсын хэмжээнд 2017 оны эхний улиралд 16542 эх амаржиж, 16642 хүүхэд төрж, мөн нас баралт 3897 болж өмнөх оны мөн үеэс амаржсан эх 2501 (13.1%)-ээр, төрсөн хүүхэд 2499 (13.1)-өөр, нас баралт 249 (6.0%)-өөр өмнөх оны мөн үеэс буурчээ.

1000 хүнд ногдох төрөлт 5.3, нас баралт 1.2, ердийн цэвэр өсөлт 4.1 болов.

Өмнөх оны мөн үеэс 1000 хүнд ногдох төрөлт 1.1 пункт, нас баралт 0.2 пункт, хүн амын ердийн цэвэр өсөлт 0.9 пунктээр буурсан байна.

Зураг I.1 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, жил бүрийн эцсийн байдлаар



1000 хүнд ногдох төрөлт улсын дунджаас Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Дорнод, Ховд, Говьсүмбэр, Увс аймагт 0.2-1.6 пунктээр дээгүүр, Орхон аймагт ижил түвшинд, бусад аймагт 0.1-2.2 пунктээр доогуур байна.

1000 хүнд ногдох нас баралт улсын дунджаас Улаанбаатар хот болон Хөвсгөл, Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр, Дундговь, Ховд, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод аймагт 0.1-0.3 пунктээр дээгүүр, харин Увс, Булган, Орхон, Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ, Сүхбаатар аймагт ижил түвшинд бусад аймагт 0.1-0.2 пунктээр доогуур байна.

Хүн амын ердийн цэвэр өсөлт улсын дунджаас Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Дорнод, Ховд, Говьсүмбэр, Увс, Архангай аймагт 0.1-1.4 пунктээр дээгүүр, Орхон аймаг ижил түвшинд, бусад аймагт 0.1-2.1 пунктээр доогуур байна.




## 1.2 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2017 оны 3 дугаар сарын эцэст 47.6 мянга болж, 34.4 (72.2%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 13.2 (27.8%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 1.0 (2.9%) мянган хүнээр буурч, өмнөх сараас 311 (0.9%) хүнээр өсч 34.4 мянга болсны 17.8 (51.8%) мянга нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 11.8 (34.2%) мянга нь Улаанбаатарт, 7.2 (21.0%) мянга нь Хангайн бүсэд, 6.4 (18.7%) мянга нь Төвийн бүсэд, 5.8 (16.8%) мянга нь Баруун бүсэд, 3.2 (9.3%) мянга нь Зүүн бүсэд байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2017 оны эхний улиралд ажилгүй 18.8 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 2.6 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 16.2 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 10.2 (35.3%) мянган хүнээр, ажилд зуучлагдан орсон иргэд 1.6 (38.6%) мянган хүнээр, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 6.0 (26.9%) мянган хүнээр буурчээ.

Зураг 1.2 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, сараар




Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сар бүрийн мэдээлэл

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 45.4 хувийг бүрэн дунд, 31.2 хувийг дипломын дээд болон бакалаврын, 6.9 хувийг техникийн болон мэргэжлийн, 5.9 хувийг суурь, 5.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.1 хувийг бага, 1.8 хувийг магистр, доктор, 1.2 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.6 хувийг 15-34 насны залуучууд эзэлж, энэ үзүүлэлт Өмнөговь, Төв, Сүхбаатар, Өвөрхангай, Ховд, Сэлэнгэ, Архангай, Дорноговь, Дорнод, Орхон, Увс, Дундговь, Говь-Алтай, Хөвсгөл аймагт улсын дунджаас 0.8-10.5 пунктээр илүү байна.

Зураг 1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2017 оны 2 дугаар сарын эцэст, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сар бүрийн мэдээлэл



### Үйлдвэрлэлийн осол, хордлого

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр үйлдвэрлэлийн осол 2017 оны эхний улиралд 76 бүртгэгдэж, өмнөх улирлаас 65 (46.1%)-аар буурсан байна. Харин энэ хугацаанд хурц хордлого гараагүй байна.

Нийт үйлдвэрлэлийн ослын 52.6 хувь нь унах, бүдрэх, хальтрах, 17.1 хувь нь эд зүйлд хавчуулагдах, харин унаж буй эд зүйлд цохигдох, эд зүйл дээр гишгэх, суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдох, халалт, түлэгдэлт, хөлдөлт тус бүр 6.6 хувь, 10.5 хувь нь бусад шалтгааны улмаас гарсан осол эзэлж байна.

Зураг 1.4. Үйлдвэрлэлийн осол, ослын шалтгаанаар, 2017 оны эхний улирлын байдлаар



Үйлдвэрлэлийн ослын улмаас нийт осолдогчдын 37 (48.7%) нь хүнд, 35 (46.0%) нь хөнгөн хэлбэрээр гэмтэж, 4 (5.3%) нь нас барсан байна.

Осолдогчдыг насны бүлгээр авч үзвэл, 39.5 хувийг 45-59 насны, 30.3 хувийг 25-34 насны, 22.4 хувийг 35-44 насны хүмүүс эзэлж байна.

Үйлдвэрлэлийн осолд осолдогчдын 34 (44.7%) нь эмэгтэйчүүд байна. Мөн нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр авч үзвэл 40.8 хувь нь энгийн ажил мэргэжилтэй, 15.8 хувь нь мэргэжилтэн, 11.8 хувь нь контор үйлчилгээний ажилтан, 10.5 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 7.9 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй, 13.2 хувь нь бусад мэргэжилтэй байна.



Зураг 1.5. Осолдогчид, ажил мэргэжлээр, 2016 оны эхний улирлын байдлаар




### 1.3 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний улиралд 484.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 82.2 (20.4%) тэрбум төгрөг, зарлага 450.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 47.4 (11.8%) тэрбум төгрөгөөр өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 82.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 60.5 (21.2%) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 7.6 (11.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2017 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 47.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 31.5 (10.0%) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 9.6 (19.2%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 3.0 (41.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Зураг 1.6 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны 3 дугаар сард 180.2 тэрбум төгрөг, зарлага 154.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас орлого 11.9 (7.1%) тэрбум төгрөгөөр өсөж, зарлага 6.7 (4.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2017 оны эхний улиралд 170.3 мянган хүнд 33.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 18.2 (9.7%) мянгаар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 3.1 (8.5%) тэрбум төгрөгөөр буурчээ. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2017 оны эхний улиралд 49.4 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 7.8 (13.7%) мянгаар, олгосон тэтгэврийн хэмжээ 1.8 (8.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2017 оны эхний улиралд 270.0 мянган хүн хамрагдсаны 80.1 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 16.2 хувь нь ахмад настан, 2.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0.9 хувь нь алдар цолтой ахмад настай иргэд, 0.1 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 36.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 275.3 (0.8%) сая төгрөгөөр буурчээ.


2017 оны эхний улиралд 18 хүртэлх насны 651.8 мянган хүүхдэд 38.1 тэрбум төгрөгийг (2017 оны 3 дугаар сард 633.7 мянган хүүхдэд 12.6 тэрбум төгрөг олгосныг оруулж тооцсон дүнгээр) хүүхдийн мөнгөн тэтгэмжид олгожээ.



#### I.4 Эрүүл мэнд


Улсын хэмжээнд 2017 оны эхний улиралд 16542 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 16642 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 2501 (13.1%)-ээр, амьд төрсөн хүүхэд 2499 (13.1)-өөр буурсан байна. Энэ оны 3 дугаар сард 6337 эх амаржиж, 6369 хүүхэд төрүүлсэн нь өмнөх сараас амаржсан эх 1596 (33.7%)-гаар, амьд төрсөн хүүхэд 1598 (33.5%)-аар өссөн байна.

Зураг I.7 Амьд төрөлт, сараар, мянган хүн




Улсын хэмжээгээр нялхсын эндэгдэл 2017 оны эхний улиралд 269 болж, өмнөх оны мөн үеэс 158 (37.0%)-аар, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 396 болж, өмнөх оны мөн үеэс 95 (19.3%)-аар буурсан байна. Нялхсын эндэгдэл энэ оны 3 дугаар сард 91 болж, өмнөх сараас 7 (8.3%)-гоор нэмэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 104 болж, 75 (41.9%)-аар буурсан байна.

Зураг I.8 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, сараар



1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2017 оны эхний улиралд 16.2 болж, өмнөх оны мөн үеэс 6 хүүхдээр, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 18.7 болж, өмнөх оны мөн үеэс 7 хүүхдээр буурсан байна. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2017 оны 3 дугаар сард 14.3 болж, өмнөх сараас 3 хүүхдээр, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16.3 болж, 1 хүүхдээр буурсан байна.


Зураг I.9 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, сараар



Эхийн эндэгдэл 2017 оны эхний улиралд 5 болж, өмнөх оны мөн үеэс 7 (58.3%)-гоор буурлаа. Харин 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2017 оны эхний улиралд 0.3 болж, өмнөх оны мөн үеэс 0.6 (0.3)-гаар буурчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2017 оны эхний улиралд 11543 болж, өмнөх оны мөн үеэс 13810 (54.5%)-аар буурахад улаанбурхнаар өвчлөгчид 15526 (99.9%)-гаар, сүрьеэгээр өвчлөгчид 130 (12.6%)-аар, вируст гепатитаар өвчлөгчид 11 (7.7%)-ээр, трихомониазаар өвчлөгчид 44 (3.3%)-өөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 600 (50.6%)-гаар, салхин цэцгээр өвчлөгчид 1061 (49.8%)-ээр, мөөгөнцрөөр өвчлөгчид 54 (13.4%)-өөр, гонококкт халдвараар өвчлөгчид 47 (4.2%)-гоор өссөн байна.

Зураг I.10 Халдварт өвчнөөр өвчлөгчид, сараар, мянган хүн



Улаанбаатар хотод 2017 оны 3 дугаар сард ХДХВ/ДОХ-ын 5 тохиолдол илэрч, улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 234 болсон байна.




## I.5 Байгаль орчин

### Цаг уур, агаарын бохирдол


Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2017 оны 3 дугаар сард хамгийн их хур тунадас Өмнөговь аймгийн Булган суманд 37.9 мм-т хүрсэн байна. Агаарын үнэмлэхүй их температур Баянхонгор аймгийн Жинст суманд 20.0 хэм, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -39.0 хэмд хүрлээ. Салхины үнэмлэхүй их хурд Говь-Алтай аймгийн Бугат суманд түр зуур 20м/с хүрсэн байна.

Чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас азотын давхар ислийн хоногийн дундаж хүлцэх агууламж 2017 оны 3 дугаар сард Улаанбаатар хотын Баруун 4 зам болон 13-р хороолол орчимд 31 удаа, Зурагт орчимд 5 удаа, Амгалан орчимд 3 удаа, 1-р хороолол, Хархорин зах болон Толгойт орчимд тус бүр 2 удаа, Офицеруудын ордон болон Ургах наран хороолол орчимд тус бүр 1 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж хүлцэх агууламж Зурагт орчимд 21 удаа, 13-р хороолол орчимд 10 удаа, Амгалан орчимд 6 удаа, Толгойт орчимд 4 удаа, Мишээл экспо төв орчимд 3 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны хүлцэх агууламж Амгалан орчимд 24 удаа, 32-ын тойрог болон Хархорин захын орчимд тус бүр 22 удаа, Зурагт орчимд 20 удаа, Баруун 4 зам болон 1-р хороолол орчимд тус бүр 19 удаа, 13-р хороолол орчимд 16 удаа, Нисэх орчимд 12 удаа, Ургах наран хороолол орчимд 1 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны хүлцэх агууламж Зурагт орчимд 25 удаа, Нисэх орчимд 17 удаа, Амгалан орчимд 14 удаа, Баруун 4 зам орчимд 11 удаа, 13-р хороолол орчимд 10 удаа, Толгойт орчимд 2 удаа давсан байна.


Зураг I.11 Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м<sup>3</sup>)




Зураг I.12 Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м<sup>3</sup>)



Зураг I.13 Улаанбаатар хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м<sup>3</sup>)



Зураг I.14 Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м<sup>3</sup>)



## Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2017 оны эхний улиралд 974 болж, өмнөх оны мөн үеэс 98 (9.1%)-аар буурав. Объектын түймэр 855 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 119 (12.2%)-аар буурав. Мал, амьтны халдварт хонины цэцэг өвчин 39 удаа, галзуу өвчин 23 удаа, шүлхий өвчин 10 удаа бүртгэгдэж, объектын түймрийн улмаас 17 хүн, бичил уурхайн нурангийн ослын улмаас 5 хүн, хүчтэй салхи, шуурганы улмаас 4 хүн, химийн бодис болон усны ослын улмаас тус бүр 3 хүн амь насаа алдаж, 174.7 мянган толгой мал, тэжээвэр амьтан хорогдлоо.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 6753.3 сая төгрөгийн хохирол учирч, 84.6 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт I.1 Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний улирлын байдлаар<sup>1</sup>

Үзүүлэлт	2014 I-III	2015 I-III	2016 I-III	2017 I-III	2017 I-III, % 2016 I-III
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	1 318	1 367	1 072	974	90.9
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүн	37	29	11	32	2.9 <sup>2</sup>
Шатсан гэр, орон сууц	704	537	475	436	91.8
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, толгой	3 711	1 288	250 303	174 701	69.8
Объектын түймэр	1 189	1 237	974	855	87.8
Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төгрөг	4.1	3.7	8.3	6.8	81.2



<sup>1</sup> Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын мэдээлэл

<sup>2</sup> Дахин их



## I.6 Гэмт хэрэг

Улсын хэмжээгээр 2017 оны эхний улиралд 6869 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 331 (4.6 %)-ээр буурчээ. Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг буурахад өмчлөх эрхийн эсрэг 489 (12.9%), нийгмийн аюулгүй байдлын эсрэг 30 (7.7%) –аар буурсан нь голлон нөлөөлөв.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2017 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 38 (19.1%), эмэгтэй хүн оролцсон хэрэг 13 (1.6%), согтуугаар үйлдэгдсэн хэрэг 68 (4.9%)-аар өсөж, харин бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 68 (13.4%)-аар буурчээ.

Зураг I.15 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



18, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг 2017 оны эхний улиралд улсын дунджаар 34 болж, өмнөх оны мөн үеэс 3 (8.1%)-аар буурсан байна.


Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны эхний улиралд 72.0 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 28.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 51.8 (3.6 дахин) тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 22.0 (4.3 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 2017 оны эхний улиралд 2690 хүн гэмтэж, 301 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 145 (5.7%), нас барсан хүн 78 (35.0%)-аар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2017 оны эхний улиралд 6.8 мянга болж, 336 (4.9%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 2736 (40.0%) нь эмэгтэйчүүд байна.


Улсын хэмжээгээр 2017 оны эхний улиралд 23.0 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 2592 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 239 (1.0%)-өөр буурч, баривчлагдсан хүн 1183(84.0%)-аар өссөн байна.

Зураг 1.16 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 389 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11 (2.8 %)–ээр буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 2017 оны 3 дугаар сард 105 болж, өмнөх сараас 20 (16.0%)–оор буурсан байна.

Зураг 1.17 Гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүн, үүнээс гэмтсэн, нас барсан хүн, сараар



Малын хулгайн гэмт хэрэг 302 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 4.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 81 (36.7%)–ээр өссөн байна. Харин малын хулгайн гэмт хэрэг 2017 оны 3 дугаар сард 48 болж, өмнөх сараас 62 (56.4%)–оор буурчээ.



## II. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### II.1 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2017 оны 3 дугаар сарын эцэст 12.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 79.5 (0.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2065.3 (20.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хүснэгт II.1 Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2015		2016		2017	
	III	III	II	III	II	III
Мөнгөний нийлүүлэлт, M2	9 902.5	10 112.4	12 257.2	12 177.7		
Жилийн өөрчлөлт, хувиар	-0.5	2.1	22.4	20.4		
Сарын өөрчлөлт, хувиар	-3.2	1.0	3.2	-0.6		
Нийт хадгаламж	7 369.0	7 571.0	8 692.3	8 786.9		
Жилийн өөрчлөлт, хувиар	-2.6	2.7	16.9	16.1		
Сарын өөрчлөлт, хувиар	-1.9	1.8	3.0	1.1		
Төгрөгийн хадгаламж	5 187.7	5 467.3	6 285.7	6 447.8		
Жилийн өөрчлөлт, хувиар	0.1	5.4	17.1	17.9		
Сарын өөрчлөлт, хувиар	-3.3	1.8	6.6	2.6		
Валютын хадгаламж	2 181.4	2 103.6	2 406.6	2 339.1		
Жилийн өөрчлөлт, хувиар	9.3	-3.6	16.6	11.2		
Сарын өөрчлөлт, хувиар	1.6	1.9	-5.5	-2.8		

Мөнгөний нийлүүлэлт 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас 79.5 тэрбум төгрөгөөр буурахад төгрөгийн хадгаламж 162.2 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 44.3 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч валютын харилцах 111.9 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 107.2 тэрбум төгрөг, валютын хадгаламж 67.5 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөллөө.


Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2017 оны 3 дугаар сарын эцэст 788.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 156.5 (16.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 129.7 (19.7%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 3 дугаар сарын эцэст 12.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 94.5 (0.8%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 842.6 (7.1%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 3 дугаар сарын эцэст 995.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 55.2 (5.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 30.1 (3.1%) тэрбум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.8 хувийг эзэлж, өмнөх сараас 0.5 пункт, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2017 оны 3 дугаар сарын эцэст 1035.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 34.6 (3.2%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 67.6 (7.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.2 хувийг эзэлж, өмнөх сараас 0.3 пункт, өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй байна.

Зураг II.1 Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг




Үнэт цаасны арилжаагаар 2017 оны 1 дүгээр улиралд 224.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 30.5 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 157.0 (3.3 дахин) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх улирлаас 23.7 (0.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Арилжсан үнэт цаас өмнөх оны мөн үеэс 5.6 (15.6%) сая ширхэг, өмнөх улирлаас 12.0 (28.2%) сая ширхэгээр буурчээ.

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2017 оны 1 дүгээр улиралд 99.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 78.3 (4.6 дахин) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 32.7 (3.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2017 оны 3 дугаар сард 12 679.1 нэгж болж, өмнөх сараас 556.9 нэгж, өмнөх оны мөн үеэс 1487.9 нэгжээр өсчээ. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2017 оны 3 дугаар сард 1429.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 96.1 (6.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг II.2 ТОП-20 индекс, сарын дундаж, нэгжээр



Төгрөгийн америк доллартай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 3 дугаар сард 2459.55 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 413.21 (20.2%) төгрөгөөр суларчээ. Харин өмнөх сараас 0.8 хувиар чангарсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 3 дугаар сард 356.57 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 42.1 (13.4%) төгрөгөөр суларч, өмнөх сараас 1.1 хувиар чангарсан байна.

Төгрөгийн рубльтэй харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 3 дугаар сард 42.51 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.33 (45.7%) төгрөг, өмнөх сараас 0.2 хувиар суларсан байна.

Хүснэгт II.2 Валютын ханш, Монголбанкны төгрөгийн валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төгрөг

Үзүүлэлт	2015	2016	2017	
	III	III	II	III
Америк доллар	1 986.22	2 046.35	2 478.29	2 459.55
Жилийн өөрчлөлт, хувиар	12.1	3.0	22.4	20.2
Сарын өөрчлөлт, хувиар	1.2	1.1	- 0.4	- 0.8
Евро	2153.45	2 273.91	2 639.10	2631.77
Жилийн өөрчлөлт, хувиар	- 12.1	5.6	17.7	15.7
Сарын өөрчлөлт, хувиар	- 3.4	1.5	- 0.1	- 0.3
Юань	318.35	314.47	360.52	356.57
Жилийн өөрчлөлт, хувиар	10.9	- 1.2	16.6	13.4
Сарын өөрчлөлт, хувиар	1.5	1.7	0.1	- 1.1
Рубль	33.0	29.18	42.43	42.51
Жилийн өөрчлөлт, хувиар	- 32.6	- 11.6	60.9	45.7
Сарын өөрчлөлт, хувиар	8.8	10.7	2.0	0.2








## II.2 Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2017 оны эхний улиралд 1504.1 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1759.2 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 255.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 360.6 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 34.5 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Зураг II.3 Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний улиралд, тэрбум төгрөг



\*Урьдчилсан гүйцэтгэл

Татварын нийт орлого 1289.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 316.6 (32.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд онцгой албан татварын орлого 28.8 (22.4%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч орлогын албан татвар 169.8 (96.1%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 73.8 (32.4%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 38.3 (42.6%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 31.6 (57.9%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 28.3 (10.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 79.8 хувийг татварын орлого, 13.3 хувийг татварын бус орлого, 5.2 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 1.7 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2017 оны эхний улиралд 1759.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 48.3 (2.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн зардал 98.2 (36.3%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч урсгал зардал 117.9 (8.2%) тэрбум төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 28.7 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 88.0 хувь, хөрөнгийн зардал 9.8 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс хөрөнгийн зардлынх 6.0 пунктээр буурч, урсгал зардлынх 4.4 пункт, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийнх 1.6 пунктээр өссөн байна.






## II.4 Гадаад худалдаа

Монгол Улс 2017 оны эхний улиралд дэлхийн 119 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2076.1 сая америк доллар, үүнээс экспорт 1299.9 сая америк доллар, импорт 776.2 сая америк доллар байна.

Зураг II.4 Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар



<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 518.1 (33.3%) сая америк доллар, үүнээс экспорт 340.9 (35.6%) сая америк доллараар, импорт 177.2 (29.6%) сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2016 оны эхний улиралд 359.9 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2017 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 163.8(45.5%) сая америк доллараар нэмэгдэж, 523.7 сая америк долларт хүрчээ.

Экспорт 2017 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 340.9 (35.6%) сая америк доллараар өсөхөд үнэт чулуу, металл гоёлын зүйлийн экспорт 67.9 сая америк доллараар буурсан хэдий ч эрдэс бүтээгдэхүүний экспорт 426.5 сая америк доллар, үүнээс нүүрсний экспорт 442.1 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 177.2 (29.6%) сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 62.9 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 44.4 сая америк доллар, авто бензин 18.8 сая америк доллараар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 52.4 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 27.7 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.


Хүснэгт II.3 Экспорт, импорт, зарим барааны бүлгээр, сая америк доллар

Үзүүлэлт	2015 I-III	2016 <sup>1</sup> I-III	2017 <sup>1</sup> I-III	$\frac{2017^1 \text{ I-III}}{2016^1 \text{ I-III}} \%$
<b>Экспорт</b>	<b>1 077.7</b>	<b>959.0</b>	<b>1 299.9</b>	<b>135.6</b>
Эрдэс бүтээгдэхүүн	871.1	733.4	1 159.9	158.2
Үүнээс: Нүүрс	141.3	99.2	541.3	5.52
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	18.2	14.6	24.1	165.2
Түүхий болон боловсруулсан арьс, шир	11.5	12.6	10.5	83.7
Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн	20.9	22.5	24.6	109.2
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	98.2	111.7	43.7	39.2
<b>Импорт</b>	<b>701.7</b>	<b>599.1</b>	<b>776.2</b>	<b>129.6</b>
Эрдэс бүтээгдэхүүн	198.5	129.2	192.0	148.7
Үүнээс: Автобензин	71.0	40.3	59.2	146.7
Дизелийн түлш	77.4	35.2	79.6	2.32
Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	64.5	69.3	96.9	140.0
Машин, механик төхөөрөмж	125.4	123.1	175.5	142.6

<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл

<sup>2</sup> Дахин их


Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 94.5 хувийг эзэлж байгаа бол импортын 69.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.



## II.5 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны эцсээс 3.1 хувь, өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар өссөн байна.

Зураг II.5 Хэрэглээний үнийн улсын индекс (өмнөх оны 12 дугаар сар =100), хувь



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь (сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 7.8 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 1.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт II.4 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, 2017 оны 3 дугаар сард


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2017 III	2017 III	2017 III
		2016 III	2016 XII	2017 I
хувь				
Ерөнхий индекс	100.0	102.1	102.1	100.9
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	102.7	109.7	103.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	102.5	100.8	100.2
Хувцас, бөс бараа, гутал	16.1	101.2	99.9	99.7
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	104.2	101.4	100.5
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	101.4	100.3	99.5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	105.2	102.0	100.5
Тээвэр	12.2	101.8	101.1	100.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.8	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.1	98.8	99.7
Боловсролын үйлчилгээ	4.7	102.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	101.2	100.0	100.5
Бусад бараа, үйлчилгээ	4.1	106.7	103.1	100.9

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны жилийн эцсээс 3.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.7 хувиар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 26.9 хувь) өссөн нь голлон нөлөөллөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувиар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 8.2 хувь) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас Дорнод, Говь-Алтай аймагт 0.1-0.3 хувиар буурч, Дархан-Уул аймагт өөрчлөлтгүй, Улаанбаатар хот болон бусад 18 аймагт 0.1-2.5 хувиар өсжээ. Дорнод аймагт 0.3 хувиар буурч, Хөвсгөл аймагт 2.5 хувиар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Зураг II.6 Хэрэглээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр 2017 оны 3 дугаар сард (өмнөх сар = 100%)




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас 1.3 хувь, өмнөх оны эцсээс 3.4 хувь, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 2.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны эцсээс 3.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 11.3 хувиар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлэг 28.2 хувь) өссөн нь голлон нөлөөллөө.

Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт, аймаг, нийслэлээр, 2017 оны 3 дугаар сард



Харин өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувиар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувь) өссөн нь голлон нөлөөллөө.


Улаанбаатар хотод 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 26.5 хувийнх нь үнэ өсөж, 9.7 хувийнх нь буурч, 63.8 хувийнх нь үнэ тогтвортой байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 62.4 хувь буюу 58 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

### Орон сууцны үнийн индекс


Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнийн индекс 2017 оны 1 дүгээр улиралд 2010 оны эцсээс 83.0 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 4.8 хувь, өмнөх улирлаас 0.2 хувиар буурсан байна.

Орон сууцны үнийн индекс 2017 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс Сонгинохайрхан дүүрэгт 6.6 хувь, Баянгол дүүрэгт 5.3 хувь, Чингэлтэй дүүрэгт 4.4 хувь, Баянзүрх дүүрэгт 4.2 хувь, Сүхбаатар дүүрэгт 3.7 хувь, Хан-Уул дүүрэгт 3.5 хувиар, өмнөх улирлаас Баянгол болон Сонгинохайрхан дүүрэгт 0.2 хувь, бусад 4 дүүрэгт тус бүр 0.1 хувиар буурсан байна.

Зураг II.7. Орон сууцны үнийн индекс, 2017 оны 1 дүгээр улиралд, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээр, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Зураг II.8. Орон сууцны үнийн индекс, 2017 оны 1 дүгээр улиралд, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээр, өмнөх улиралтай харьцуулснаар



1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнийн индекс 2017 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 6 дүүрэгт 3.5-5.8 хувиар, 1970-2001 оны орон сууцных 2.9-6.2 хувиар, 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцных 3.1-9.5 хувиар буурсан байна.

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнийн индекс 2017 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлаас Баянгол болон Сонгинохайрхан дүүрэгт өөрчлөлтгүй, бусад 4 дүүрэгт 0.1 хувиар, 1970-2001 оны орон сууцных болон 2002 оноос хойших орон сууцны үнийн индекс 6 дүүрэгт 0.1-0.2 хувиар буурчээ




### Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.2 хувь буурч, харин өмнөх оны эцсээс 24.0 хувь, өмнөх оны мөн үеэс 70.1 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.2 хувиар буурахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.4 хувиар (газрын тос, шатдаг хий олборлолтын үнэ 2.6 хувь, металлын хүдэр олборлолтын үнэ 1.4 хувь), цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.8 хувь (ус ариутгал, усан хангамжийн үнэ 3.8 хувь) буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг I.9 Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (өмнөх сар =100)



### Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээгээр 2017 оны 3 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай ширний дундаж үнэ Сүхбаатар, Говь-Алтай, Өвөрхангай, Хөвсгөл аймагт хамгийн бага буюу 15.0-20.0 мянган төгрөг; Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 35.0-39.5 мянган төгрөг; адууны ширний дундаж үнэ Говь-Алтай, Сүхбаатар, Булган аймагт хамгийн бага буюу 15.0-17.5 мянган төгрөг; Дундговь, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 31.0-33.0 мянган төгрөг; ямааны 1 килограмм цагаан ноолуурын үнэ Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Ховд, Өмнөговь аймагт хамгийн бага буюу 64.0-65.0 мянган төгрөг; Хөвсгөл, Төв, Сүхбаатар, Говьсүмбэр, Дундговь, Дорнод аймагт хамгийн их буюу 90.0-100.0 мянган төгрөг байна.



### II.6 Статистикийн бизнес регистрийн сан

Статистикийн бизнес регистрийн санд 2017 эхний улирлын байдлаар 145.1 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 73.3 (50.5%) мянга нь үйл ажиллагаа явуулж байна.

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 46.8 (63.8%) мянга нь Улаанбаатар хотод, 8.6 (11.8%) мянга нь Төвийн бүс, 8.1 (11.0%) мянга нь Хангайн бүс, 6.6 (9.0%) мянга нь Баруун бүс, 3.2 (4.3%) мянга нь Зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 84.2 хувь нь 1-9 ажиллагчидтай, 7.0 хувь нь 10-19 ажиллагчидтай, 5.5 хувь нь 20-49 ажиллагчидтай, 3.3 хувь нь 50-иас дээш ажиллагчидтай байна.

Үйл ажиллагаа явуулаагүй 71.8 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 33.0 (46.0%) мянга нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 34.7 (48.2%) мянга нь түр зогсоосон, 1.5 (2.1%) мянга нь бүрэн зогсоосон, 2.6 (3.6%) мянга нь хаяг тодорхойгүй болон бусад шалтгаантай байна.






## II.6 Мал аж ахуй

Улсын хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 26.5 сая хээлтэгч малын 5.5 сая (20.9%) нь 2017 оны эхний улиралд төллөсөн байна. Эм хонины 23.1 хувь, эм ямааны 22.5 хувь, ингэний 11.2 хувь, үнээний 6.5 хувь, гүүний 2.0 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.5 хувь буюу 5.5 сая төл бойжиж, өмнөх оны мөн үеэс 550.0 (9.2%) мянгаар буурсан байна.

Зураг II.10 Том малын зүй бус хорогдол, жил бүрийн эхний улирлын байдлаар, мянган толгой



Том малын зүй бус хорогдол 2017 оны эхний улиралд улсын хэмжээнд 269.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 561.5 (67.6%) мянгаар буурав. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, адуу 11.1 мянга, үхэр 30.0 мянга, тэмээ 107, хонь 114.5 мянга, ямаа 113.3 мянга байна. Нийт хорогдсон малын 42.6 хувийг хонь, 42.1 хувийг ямаа эзэлж байна.

Улсын хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2017 оны эхний улиралд 17.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.5 (16.5 хувь) мянгаар нэмэгдэв.



## II.7 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 2697.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 891.3 (49.4%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 758.8 (63.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.


Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2017 оны 3 дугаар сард 158.5 (2010=100) болж, өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар өсөж, өмнөх оны эцсээс 0.5 хувиар, өмнөх сараас 6.8 хувиар буурчээ.

Өмнөх оны мөн үеэс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт буталмал чулуу, алт, молибдений баяжмал, нүүрс, төмрийн хүдэр зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт 2.1 хувиас 4.0 дахин, боловсруулах аж үйлдвэрийн салбарт зүсмэл материал, хиаман төрлийн бүтээгдэхүүн, архи, шар айраг, вакуум цонх, хаалга, ноолууран сүлжмэл эдлэл, банш, бууз, малын тэжээл, адууны мах зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.9 хувиас 2.6 дахин өссөн байна.

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт цайрын баяжмал, хайлуур жонш, зэсийн баяжмал, газрын тос зэрэг бүтээгдэхүүний олборлолт 5.5-21.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт катодын зэс, гоо сайхны тос, самнасан ноолуур, барилгын модон хаалга, цонх зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.7-78.1 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2017 оны эхний улиралд 3237.8 тэрбум төгрөгт хүрч, 2344.1 тэрбум төгрөг буюу 72.4 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Зураг II.11 Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, тэрбум төгрөг, сараар




<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл



## II.8 Их барилга

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2017 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 101.6 тэрбум төгрөг болж, 101.0 (99.3%) тэрбум төгрөгийг дотоодын, 0.7 (0.7%) тэрбум төгрөгийг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Зураг II.12 Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, улирлаар, тэрбум төгрөг



<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл



Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2017 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 16.5 (14.0%) тэрбум төгрөгөөр буурахад дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажлын хэмжээ 15.3 (13.2%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

Барилга угсралт, их засварын ажлын 60.6 хувийг орон сууцны барилга, 26.3 хувийг орон сууцны бус барилга, 11.3 хувийг инженерийн барилга, байгууламж, 1.8 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны бус барилгын ажлын эзлэх хувь 10.1 пункт, их засварын ажлынх 0.5 пунктээр нэмэгдэж, харин орон сууцны барилгынх 9.6 пункт, инженерийн барилга, байгууламжийнх 0.9 пунктээр буурсан байна.



## II.9 Тээвэр, холбоо


Бүх төрлийн тээврээр 2017 оны эхний улиралд 10.0 сая тонн ачаа, давхардсан тоогоор 45.1 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 3.0 (42.7%) сая тонноор өсөж, зорчигчид 8.6 (16.0%) сая хүнээр буурчээ.

Авто тээврээр 2017 оны эхний улиралд 5.1 сая тонн ачаа, давхардсан тоогоор 44.3 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 2.5 (96.8%) сая тонноор өсөж, зорчигчид 8.6 (16.3%) сая хүнээр буурчээ.

Авто тээврийн салбарын орлого 2017 оны эхний улиралд 102.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 17.5 (20.7%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Төмөр замын тээврээр 2017 оны эхний улиралд 4.9 сая тонн ачаа, давхардсан тоогоор 635.1 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 479.3 (10.9%) мянган тонноор өсөж, зорчигчид 2.1 (0.3%) мянгаар буурчээ. Харин өмнөх сараас тээсэн ачаа 245.3 (16.7%) мянган тонн, зорчигчид 29.6 (15.4%) мянган хүнээр өссөн байна.

Зураг II.13 Төмөр зам болон агаарын тээврээр тээсэн ачаа




<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл

Төмөр замаар 2017 оны эхний улиралд нийт тээсэн ачаанд дотоодын ачаа 48.5 хувь, экспортын ачаа 31.7 хувь, импортынх 8.6 хувь, дамжин өнгөрсөн ачааных 11.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс экспортын ачааных 1.5 пункт, дотоодын ачааных 0.4 пунктээр өсөж, харин импортын ачааных 1.0 пункт, дамжин өнгөрсөн ачааных 0.9 пунктээр буурсан байна.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2017 оны эхний улиралд 105.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 17.0 (19.3%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Агаарын тээврээр 2017 оны эхний улиралд 630.7 тонн ачаа, давхардсан тоогоор 152.2 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 5.1 (0.8%) тонноор буурч, зорчигчид 24.5 (19.2%) мянган хүнээр өсжээ. Харин өмнөх сараас тээсэн ачаа 34.0 (17.6%) тонн, зорчигчид 6.7 (14.5%) мянган хүнээр өссөн байна.

Зураг II.14 Төмөр зам болон агаарын тээврээр зорчсон зорчигчид



Агаарын тээврээр 2017 оны эхний улиралд дотоод зорчигчид 64.6 (42.4%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 22.5 (53.7%) мянга, олон улсад зорчигчид 87.5 (57.5%) мянга болж, 1.9 (2.2%) мянгаар өсжээ.




Агаарын тээврийн салбарын орлого 2017 оны эхний улиралд 56.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.7 (9.0%) тэрбум төгрөг, өмнөх сараас 2.5 (14.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

### Харилцаа, холбоо

Шуудан, холбооны салбарын нийт орлого 2017 оны эхний улиралд 180.7 тэрбум төгрөг, хүн амаас орсон орлого 120.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс шуудан, холбооны нийт орлого 11.5 (6.8%) тэрбум төгрөг, хүн амаас орсон орлого 0.6 (0.5%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Зураг II.15 . Шуудан, холбооны салбарын орлого



Суурин утасны цэгийн тоо 2017 оны эхний улиралд 275.2 мянган ширхэг, кабелийн телевиз хэрэглэгчид 440.7 мянга болж өмнөх оны мөн үеэс суурин утасны цэг 23.7 (9.4%) мянган ширхэг, кабелийн телевиз хэрэглэгчид 61.4 (16.2%) мянгаар нэмэгдсэн байна. Үүнд гурвалсан үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хэрэглэгчид болон агаарын олон сувгийн тоон телевизийн дамжуулах үйлчилгээ нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Шуудангийн үйлчилгээний салбар 2017 оны эхний улиралд 226.0 мянган ширхэг бичиг, захидал 38.8 мянган ширхэг илгээмж, 1717.9 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэжээ.




Үүрэн утас хэрэглэгчид 2017 оны эхний улиралд давхардсан тоогоор 3402.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 408.3 (13.6%) мянгаар өсжээ.



## II.10 Аялал, жуулчлал

Манай улсын хилээр 2017 оны эхний улиралд давхардсан тоогоор 1265.9 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 232.5 (22.5%) мянгаар өсжээ. Улсын хилээр орсон зорчигчдын 36.6 хувь нь Замын-Үүд, 16.1 хувь нь Гашуун сухайт, 14.5 хувь нь Буянт-Ухаа, 12.7 хувь нь Алтанбулаг, 6.8 хувь нь Шивээ хүрэн, 13.3 хувь нь бусад боомтоор орсон байна.

Зураг II.16 Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид, улирлаар, мян.хүн



Улсын хилээр 2017 оны эхний улиралд гадаадын 78.8 мян.хүн орсон нь өмнөх оны мөн үеэс 15.2 (23.9%) мянгаар өсчээ. Тэдний 78.6 хувь нь 30 хүртэл хоног, 2.2 хувь нь 90 хүртэл хоног, 19.2 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна. Гадаадын зорчигчдын 63.6 (80.7%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон нь өмнөх оны мөн үеэс 14.0 (28.3%) мянгаар өссөн байна. Хилээр орсон гадаадын зорчигчдын 15.2 (19.3%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор иржээ.




Өмнөх оны мөн үеэс ОХУ-ын жуулчид 6981 (54.4%), БНХАУ-ынх 4578 (24.7%), БНСУ-ынх 831 (15.5%), Австрали улсынх 314 (51.7%), АНУ-ынх 206 (12.3%), Япон улсынх 140 (6.3%) хүнээр өссөн бол Тайваний жуулчид 24 (16.6%), Хонгконгийнх 39 (30.5%), Турк улсынх 58 (14.5%) хүнээр буурчээ. Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 56.1 (71.1%) мянга нь эрэгтэйчүүд, 19.9 (25.3%) мянга нь эмэгтэйчүүд, 2.8 (3.6%) мянга нь хүүхэд байна.

Энэ оны эхний улиралд улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 62.5 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас, 32.2 хувь нь Европоос, 3.9 хувь нь Америк тивээс, 1.4 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 43.8 хувийг БНХАУ-ын иргэд, 26.3 хувийг ОХУ-ын иргэд, 8.5 хувийг БНСУ-ын иргэд, 3.2 хувийг Япон улсын иргэд, 2.8 хувийг АНУ-ын иргэд, 2.8 хувийг Казахстан улсын иргэд, 12.6 хувийг бусад улсын иргэд эзэлж байна.

Энэ оны эхний улиралд манай улсын давхардсан тоогоор 560.3 мянган иргэн гадаадад зорчсоноос 406.3 (72.5%) мянга нь хувийн журмаар зорчжээ.

Зураг II.17 Монгол Улсын хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчид, бүс нутгаар, жил бүрийн эхний улирлын байдлаар, дүнд эзлэх хувиар



Улсын хилээр 2017 оны эхний улиралд давхардсан тоогоор 610.5 мянган тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 223.1 (57.6%) мянгаар өсөж, тэдгээрийн 45.0 хувийг ачааны машин, 30.3 хувийг суудлын машин, 22.5 хувийг ачааны вагон, 2.2 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслийн 89.5 хувь нь Замын-Үүд, Гашуун сухайт, Шивээ хүрэн, Алтанбулаг, Сүхбаатар боомтоор нэвтэрсэн байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



А.АРИУНЗАЯА

## Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм

### АНУ-ын эдийн засаг

АНУ-ын Эдийн засгийн судалгааны товчооны тооцоогоор улирлын нөлөөллийг арилгасан дотоодын нийт бүтээгдэхүүн, зэрэгцүүлэх үнээр 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 2.1 хувиар өсчээ<sup>1</sup>.

Улирлын нөлөөллийг арилгасан хэрэглээний үнийн индекс 2017 оны 2 дугаар сард өмнөх сараас 0.1 хувь, өмнөх оны мөн үеэс 2.7\* хувиар өссөн байна<sup>2</sup>.

Улирлын нөлөөллийг арилгасан гадаад худалдааны тэнцэл 2017 оны 2 дугаар сард 43.5 тэрбум америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 45.4 (51.1%) тэрбум америк доллараар буурчээ<sup>3</sup>.

Тус улсын Холбооны нөөцийн сангийн урьдчилсан тооцоогоор аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2017 оны 2 дугаар сард 104.7 (2012=100) болж, өмнөх сараас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өссөн байна<sup>4</sup>.

АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчооны мэдээгээр улирлын нөлөөллийг арилгасан ажилгүйдлийн түвшин 2017 оны 2 дугаар сард 4.7 хувь болж, өмнөх сараас 0.1 пунктээр буурчээ<sup>2</sup>.

### Япон улсын эдийн засаг

Япон улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны институтын тооцоогоор улирлын нөлөөллийг арилгасан, эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, зэрэгцүүлэх үнээр 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 0.3 хувь, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн байна<sup>5</sup>.

Улирлын нөлөөллийг арилгасан хэрэглээний үнийн индекс 2017 оны 2 дугаар сард 99.8 (2015=100) болж, өмнөх сараас 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.3\* хувиар өссөн байна<sup>6</sup>.

Гадаад худалдааны тэнцэл 2017 оны 2 дугаар сард 813.5 тэрбум иений ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 578.0 (3.5 дахин) тэрбум иенээр өсчээ<sup>7</sup>.

*Тайлбар* \*- Улирлын нөлөөллийг тооцоогүй.

Аж үйлдвэрийн салбарын улирлын нөлөөллийг арилгасан үйлдвэрлэлийн индекс 2017 оны 2 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 102.2 (2010=100) болж, өмнөх сараас 2.0 хувиар өссөн байна<sup>8</sup>.

Улирлын нөлөөллийг арилгасан ажилгүйдлийн түвшин 2017 оны 2 дугаар сард 2.8 хувь болж, өмнөх сараас 0.2 пунктээр буурсан байна<sup>6</sup>.

### Европын холбооны гишүүн орнуудын эдийн засаг

Европын холбооны Статистикийн газрын тооцоогоор тус холбооны гишүүн 28 орны улирлын нөлөөллийг арилгасан ДНБ, зэрэгцүүлэх үнээр 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 0.5 хувь, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн байна<sup>9</sup>.

Инфляцийн түвшин 2017 оны 2 дугаар сард 1.9 хувь болж, өмнөх сараас 0.2 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 пунктээр өссөн байна<sup>9</sup>.

Гадаад худалдааны тэнцэл 2016 онд 37.7 тэрбум еврогийн ашигтай гарч, өмнөх оноос 22.2 (37.1%) тэрбум еврогоор буурчээ<sup>9</sup>.

Аж үйлдвэрийн салбарын улирлын нөлөөллийг арилгасан үйлдвэрлэлийн индекс 2017 оны 2 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өссөн байна<sup>9</sup>.

Улирлын нөлөөллийг арилгасан ажилгүйдлийн түвшин 2017 оны 2 дугаар сард 8.0 хувь болж, өмнөх сараас 0.1 пункт, өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурчээ<sup>9</sup>.

### ОХУ-ын эдийн засаг

ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны урьдчилсан тооцоогоор улирлын нөлөөллийг арилгасан ДНБ, зэрэгцүүлэх үнээр 2016 онд өмнөх оноос 0.2 хувиар буурсан байна<sup>10</sup>.

Хэрэглээний үнийн индекс 2017 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 1.0 хувь, өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсчээ<sup>11</sup>.

Гадаад худалдааны тэнцэл 2017 оны 1 дүгээр сард 11.4 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 4.2 (58.3%) тэрбум америк доллараар өссөн байна<sup>11</sup>.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2017 оны 2 дугаар сард өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар буурчээ<sup>11</sup>.

Ажилгүйдлийн түвшин 2017 оны 2 дугаар сард 5.6 хувь болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна<sup>11</sup>.

### БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны урьдчилсан тооцоогоор ДНБ, зэрэгцүүлэх үнээр 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 1.7 хувь, өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өссөн байна<sup>12</sup>.

Хэрэглээний үнийн индекс 2017 оны 2 дугаар сард 103.5 (2015=100) болж, өмнөх сараас 0.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өссөн байна<sup>12</sup>.

Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 2 сард 42.1 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 42.8 (50.4%) тэрбум америк доллараар буурсан байна<sup>12</sup>.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2017 оны 1 дүгээр сард 154.2 (2010=100) байсан бол 2017 оны 2 дугаар сард 136.8 (2010=100) болжээ<sup>12</sup>.

Бүртгэлтэй ажилгүйдлийн түвшин хот суурин газарт 2016 оны 4 дүгээр улирлын эцэст 4.02 хувь болж, өмнөх улирлаас 0.02 пунктээр буурсан байна<sup>12</sup>.

### Зэсийн үнэ

Лондонгийн үнэт металлын биржид тонн цэвэр зэсийн үнэ 2017 оны 3 дугаар сарын дунджаар 5157.1 америк доллар болж, өмнөх сараас 784.4 (13.2%) америк доллараар буурч, өмнөх оны мөн үеэс 209.6 (4.2%) америк доллараар өссөн байна<sup>13</sup>.



### Алтны үнэ

Лондонгийн металлын биржид 1 унц алтны үнэ 2017 оны 3 дугаар сарын дунджаар 1231.1 америк доллар болж, өмнөх сараас 3.4 (0.3%) америк доллар, өмнөх оны мөн үеэс 15.2 (1.2%) америк доллараар буурчээ<sup>14</sup>.



### Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррель газрын тосны үнэ 2017 оны 3 дугаар сарын дунджаар 50.5 америк доллар болж, өмнөх сараас 4.1 (7.4%) америк доллараар буурч, өмнөх оны мөн үеэс 10.3 (25.6%) америк доллараар өссөн байна<sup>15</sup>.



